

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс 2024 онд нийт 162 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.долларт хүрсэн ба үүний 80.2 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Оросын Холбооны Улс (ОХУ) эзэлж байна. Нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа нь эдийн засгийн төрөлжилт сул, гадаад зах зээлийн савлагаа, түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий байдлыг нэмэгдүүлж байна. Мөн нийт экспортын 91.3 хувь, уул уурхайн бүтээгдэхүүний 94.7 хувь, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний 82.7 хувийг зөвхөн БНХАУ-д экспортолж байгаа нь нэг улсын зах зээлээс хэт хамааралтай болж, эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө учруулах хэмжээнд хүрээд байна. Иймд, экспортын зах зээлийг төрөлжүүлж, шинэ бүс нутаг, улсын зах зээлд нэвтрэх зайлшгүй шаардлагатай байна.

2024 оны байдлаар ОХУ-тай хийсэн худалдаа 2.7 тэрбум ам.долларын алдагдалтай байна. Сүүлийн 10 жилд ОХУ руу экспортлох хэмжээ төдийлөн нэмэгдээгүй бөгөөд шатахууны эрэлт нэмэгдсэнтэй холбоотой импорт өсөж, худалдааны бүтэц тэнцвэргүй байна. ОХУ нь Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)-ны гишүүн тул холбооны бусад гишүүн орнуудтай адил нэгдсэн гаалийн тарифын бодлого хэрэгжүүлдэг. Монгол Улсаас ЕАЭЗХ-д экспортлох бараанд 15–50 хувийн гаалийн тариф ногдуулж, эрүүл ахуй, хорио цээрийн өндөр шаардлага тавьж байгаа нь экспортын боломжийг хязгаарлаж байна.

Тиймээс Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хооронд худалдааны түр хэлэлцээр байгуулах албан ёсны хэлэлцээг 2023 оны 9 дүгээр сараас эхлүүлж, удаа дараа хийсэн олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан саналуудыг тусган эцэслэж, 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурж байгуулсан.

Тус хэлэлцээр нийт 31 зүйл, 4 хавсралтаас бүрдэх бөгөөд хөрөнгө оруулалт, үйлчилгээний худалдаа, банк санхүү, төлбөр тооцоо зэрэг асуудлыг тусгаагүй, зөвхөн 367 барааны хүрээнд тохиролцсон. Мөн хэлэлцээр 3 жилийн хугацаатай бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол хугацааг сунгасанд тооцно.

Хэлэлцээрийн хүрээнд 2 талаас ижил тооны буюу “Бараа тодорхойлох кодчлолын уялдуулсан систем” (БТКУС)-ийн 6 оронтой кодоор 367 бараанд “тарифыг шууд тэглэх”, “тариф бууруулах”, “тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх”, “тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх” гэсэн 4 төрлөөр тарифыг бууруулах, хөнгөлөлт үзүүлэхээр тохиролцсон. Энэ нь зөвхөн гаалийн тарифт хамаарах бөгөөд нэмэгдсэн өртгийн албан татвар болон онцгой албан татварт хамаарахгүй.

Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсаас экспортлох 367 барааны 97.5 хувь нь хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бараа байна. Харин ЕАЭЗХ-ноос манай улсад импортлох 367 барааны 81.7 хувь нь манай улсад үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал эрдэс, химийн салбарын, 7.5 хувь нь аж үйлдвэрийн салбарын бараа байна. Мөн улаанбуудай, өндөг зэрэг хүнсний гол нэрийн барааны импортын нөлөөллийг бага байлгах, дотоодын зах зээлийг хамгаалахад онцгойлон анхаарч

жилд импортлох хэмжээнд квот тогтоох, квотоос хэтэрсэн тохиолдолд гаалийн тарифыг хэвээр ногдуулах зэрэг дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохицуулалтыг тусгасан.

Хэлэлцээр хэрэгжсэнээр худалдааг хөнгөвчилж, үйлдвэрлэл болон бизнесийн зардал буурна. Тухайлбал, барааны өртгийн 50 хувиас дээш хэсэг Монгол Улсаас гаралтай тохиолдолд тарифын хөнгөлөлт эдлэх, барааг гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагийн дотор олгох, 5000 еврогоос бага дүнтэй бараанд гарал үүслийн гэрчилгээг үйлдвэрлэгч, экспортлогч өөрөө гаргах, эрсдэлийн үнэлгээнд суурилсан гаалийн шалгалт явуулах зэрэг зохицуулалт туссан. Мөн итгэмжлэгдсэн аж ахуй нэгжийн хөтөлбөрийг талууд хамтран хэрэгжүүлснээр бичиг баримт, шалгалтын ачаалал буурна.

Олон улсад чөлөөт худалдааны хэлэлцээр хийхэд түгээмэл ашигладаг “Ерөнхий тэнцвэрийн загвар” (GAP)-ын аргаар тооцоход хэлэлцээр хэрэгжсэнээр манай улсын ДНБ 0.02 хувь, хөрөнгө оруулалт 2.57 хувь, ЕАЭЗХ руу хийх экспорт 24.1 хувь өсөхөөр байна. Тухайлбал, мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуур, нэхмэл, сүлжмэл болон арьс шир зэрэг боловсруулах үйлдвэрийн гол бүтээгдэхүүний экспорт 152 хувь хүртэл нэмэгдэж, гаалийн татваргүйгээр 180 сая хүн ам бүхий, 5 улсын зах зээлд нэвтрэх нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн, манай улсад үйлдвэрлэдэггүй, бүтээн байгуулалт болон үйлдвэрлэлд зайлшгүй шаардагдах бараа, тоног төхөөрөмжийн татварыг тэглэснээр импортын өртөг буурч, инфляцын дарамт багасна. Инфляц тооцоход ашигладаг 42 нэрийн импортын бүтээгдэхүүний тариф тэглэгдэхээр байгаа нь өрхийн жилийн дундаж хэрэглээний зардлыг бууруулах тооцоотой байна.

Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудал нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1, 3.2.5.3, 3.2.5.4, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т тус тус тусгагдсан.

“Цагаан алт”, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо хөдөлгөөн” зэрэг төрийн бодлогын хүрээнд хөдөө аж ахуйн салбарыг дэмжих ажил идэвхтэй өрнөж буй энэ үед тус хэлэлцээр нь дотоодын боловсруулах үйлдвэрлэл болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, малчин өрх болон үйлдвэрлэгч, экспортлогчдын орлогыг өсгөх, ажлын байрыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Мөн дээр дурдсан Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бүс нутгийн интеграцид нэгдэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, экспортын зах зээлийг тэлж, төрөлжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, худалдааг хөнгөвчлөх, хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих ач холбогдолтой.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр”-ийг соёрхон батлах Монгол Улсын хуулийн төслийн тухай

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 4.4-т “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэж, худалдааг хөнгөвчилнө” гэж, “Зорилтыг хэрэгжүүлэх I үе шат болох 2021-2030 онд “Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ), Оросын Холбооны Улс (ОХУ)-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцид нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-т “Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.” гэж, 3.2.5.3-т “Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална” гэж, 3.2.5.4-т “Бүс нутгийн болон олон улсын интеграцид нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-т “Бүгд Найрамдах Солонгос Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, (ЕАЭЗХ) БНХАУ-тай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулж, худалдааны түнш улс орнуудтай хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ” гэж тусгагдсан.

Худалдааны нөхцөл байдал:

2024 оны байдлаар Монгол Улсын худалдааны салбар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 17.8 хувь, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 38.2 хувийг бүрдүүлж, 195,081 хүн буюу нийт ажиллагсдын 14.4 хувийг ажлын байраар хангаж байна¹.

Монгол Улс Япон Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг 2015 онд байгуулсан. Мөн Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт 2019 онд, Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээрт 2022 нэгдэн орж, тус тус соёрхон баталсан. Бусад улстай харьцуулахад Монгол Улс олон улсын хэмжээнд чөлөөт худалдааны гэрээ байгуулсан орны үзүүлэлтээр хамгийн цөөн гэрээ байгуулсан орны тоонд багтаж байна.

Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулснаар тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, үндэсний үйлдвэрлэгчдэд шинэ зах зээлд нэвтрэх, хөрөнгө оруулагчдад тогтвортой, урьдчилан таамаглах боломж бүхий эрх зүйн орчин бүрдүүлж,

¹ Үндэсний Статистикийн Хороо

шууд хөрөнгө оруулалт татах нэг нөхцөлийг бүрдүүлдэг. Монгол Улсын бараа, үйлчилгээ бусад орны зах зээлд ижил төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж буй өрсөлдөгч орнуудаас илүү өндөр татвар, хатуу тарифын бус шаардлагатай тулгарч байгаа нь Монгол Улсын экспортын бүтэц, хөрөнгө оруулалт татах чадавхын хувьд бусад улсын өрсөлдөгч орнуудтай харьцуулахад хязгаарлагдмал байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Үүний улмаас Монгол Улсын эдийн засаг төрөлжих болон өсөх, экспортын бараа, үйлчилгээний өрсөлдөх чадвар, гадаадын шууд хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдэх, бүс нутгийн нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэх, үйлдвэрлэлийг шаталсан хэлбэрээр гүнзгийрүүлэх, дэвшилтэт технологи, ноу-хау зэрэг шилдэг туршлагыг нэвтрүүлэх боломжийг хязгаарладаг.

Монгол Улсын нийт бараа эргэлтийн 69.5 хувийг БНХАУ, 10.7 хувийг ОХУ тус тус эзэлж байна. Манай улсын нийт экспортын 91.3 хувийг БНХАУ эзэлж байна. Энэ нь экспортын зах зээлийн хэт төвлөрөл болон хамаарлын эрсдэлийг бий болгож байгаа тул экспортын зах зээлийг төрөлжүүлэх, шинэ зах зээлд нэвтрэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улс нь далайд гарцгүй, хоёр том эдийн засгийн дунд байрладаг тул уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эдийн зах зээл болон үнийн хэлбэлзэлд тэсвэртэй байдал болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх, гадаад худалдааны зах зээлийг тэлэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, цаашлаад хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, экспортын зах зээлийг тэлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байна.

Монгол Улс, ЕАЭЗХ-ны гишүүн орнууд болох ОХУ, Бүгд Найрамдах Беларусь Улс (Беларусь), Бүгд Найрамдах Казахстан Улс (Казахстан), Бүгд Найрамдах Армени Улс (Армени), Бүгд Найрамдах Киргиз Улс (Киргиз) орнуудтай хийсэн гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 3.0 тэрбум ам.доллар байгаагаас 2.9 тэрбум ам.доллар нь импорт байна. Манай улстай хийсэн тус холбооны гишүүн 5 орны худалдааны 97.2 хувийг ОХУ, 1.8 хувийг Казахстан Улс, 0.8 хувийг Беларусь Улс, 0.1 хувийг Киргиз Улс, 0.02 хувийг Армен Улс тус тус бүрдүүлж байна. ЕАЭЗХ нь манай улсын нийт бараа эргэлтийн 11 хувь, экспортын 0.7 хувь, импортын 25 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд бараа эргэлтийн харьцаа 96:4 байна. Энэ нь гадаад худалдааны тэнцэл эрс алдагдсан байгааг харуулж байна.

ЕАЭЗХ нь гаалийн нэгдсэн нэг нутаг дэвсгэртэй ба бусад орнуудтай хийх худалдаанд гаалийн нэгдсэн нэг тарифын бодлогыг хэрэгжүүлдэг. ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын бүтээгдэхүүнд дунджаар 15-50 хувийн гаалийн тариф ногдуулж, хатуу тарифын бус шаардлагатай тулгарч байгаа нь Монгол Улсын бүтээгдэхүүн ЕАЭЗХ-ны зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадварт сөрөг нөлөө үзүүлж байгаа гол хүчин зүйл болж байна.

Олон нийтийн хэлэлцүүлэг:

Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, барааны жагсаалтын талаар санал солилцсон.

Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-ны зүгээс 2023 оны 10 дугаар сарын 20-ны 03/1978 дугаартай албан бичгээр ХХААХҮЯ болон МҮХАҮТ-аас барааны жагсаалтад санал авсан. ХХААХҮЯ-ны 2023 оны 11 дүгээр 13-ны 01/3970 дугаартай албан бичиг ирүүлсэн хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай барааны 96 хувийг манай улсаас экспортлох барааны жагсаалтад оруулсан. МҮХАҮТ-ийн 2023 оны 11 дүгээр сарын 29-ны 01/1124 тоот албан бичгээр Монгол Улсын гарал үүсэлтэй бүх барааны жагсаалтыг 2 хавсралтаар ирүүлсэн ба манай барааг 375 болгон гүйцээн жагсаалтад оруулсан.

ЭЗХЯ-ны зүгээс 2023 оны 12 дугаар 13-ны өдөр болон 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдрүүдэд 2 удаагийн төр, хувийн хэвшлийн нийт 150 гаруй төлөөлөгчидтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авсан. Тухайлбал, Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо желатин барааг экспортлох барааны жагсаалтад оруулах, хөдөлмөр хамгааллын арьсан бээлий болон гутал хамгаалах барааны жагсаалтад оруулах санал ирүүлсэн. Монголын ноос ноолуурын холбоо ОХУ-д экспортлох бараанд тулгардаг саад бэрхшээлийн талаар дурдсан. Мөн Монголын махны холбоо экспортлох барааны саналаа МҮХАҮТ-д албан бичгээр хүргүүлсэн саналыг тусгасан. Мөн, АПУ ХК-иас шингэн хүнсний бүтээгдэхүүнийг ЕАЭЗХ руу экспортлох барааны жагсаалтад оруулах санал ирүүлснийг хэлэлцээрт тусгасан.

Хэлэлцээрийн хамрах хүрээ:

Хэлэлцээр нь нийт 31 зүйл, 4 хавсралтаас бүрдэнэ. Үүнд Барааны ангилал, Гаалийн татварын хөнгөлөлт болон/эсхүл чөлөөлөлт, Гарал үүслийн дүрэм, Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөх, Гаалийн хамтын ажиллагаа, Чөлөөтэй дамжин өнгөрөх, Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ, Төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор хэрэгжүүлэх хязгаарлалт, Худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ, Ил тод байдал болон мэдээлэл солилцох, Цахим худалдаа, Эдийн засгийн хамтын ажиллагаа, Хамтарсан хороо багтаж байна.

Хэлэлцээрт хөрөнгө оруулалт, үйлчилгээний худалдаа, банк санхүү, төлбөр тооцоо зэрэг асуудлууд тусгагдаагүй, зөвхөн барааны худалдааны хүрээнд байгуулсан. Хэлэлцээрийг 3 жилийн хугацаатай байгуулах бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол тус хугацаа сунгагдсанд тооцно. Мөн энэхүү хэлэлцээрт зөвхөн гаалийн тариф хамаарах бөгөөд НӨАТ, онцгой албан татварын зохицуулалт хамаарахгүй.

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлснээр Монгол Улс ЕАЭЗХ-ны гишүүн улс болохгүй бөгөөд зөвхөн хэлэлцээрт хамрагдсан 367 нэр төрөл бүхий барааны хувьд Монгол Улс, ЕАЭЗХ болон түүний гишүүн улсуудын хоорондын худалдаанд тарифын хөнгөлөлт, илүү таатай нөхцөл бүхий эрх зүйн орчин бүрдүүлнэ.

Тарифын хөнгөлөлтийн жагсаалтын тухай:

Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 6 оронгийн түвшингийн Монгол Улсаас гаралтай 367 нэр төрлийн бараа нь 621 үндэсний кодтой

бараа, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай нийт 367 нэр төрлийн бараа нь 499 үндэсний кодтой бараа болж тус тус гаалийн цахим үйлчилгээний системд бүртгэгдэнэ.

Монголын тал хэлэлцээрийн хүрээнд нийт 367 нэр төрлийн барааг сонгосон бөгөөд эдгээр нь манай улсын харьцангуй давуу тал бүхий мах, махан бүтээгдэхүүн, арьс, ширэн бүтээгдэхүүн, ноос, ноолуурын бүтээгдэхүүн, түүнчлэн сүү, цагаан идээ, малын дайвар бүтээгдэхүүн, тэжээл зэрэг хөдөө аж ахуйн салбарын бусад бүтээгдэхүүн, давс, хайлуур жонш, зэс, молибден, тугалга, гянтболд зэрэг бусад бүлгийн бараанаас бүрдэж байна. Эдгээр нь дотоодын түүхий эдэд тулгуурласан, нэмүү өртөг шингэсэн экспортын бүтцийг төрөлжүүлэх гол бараанууд юм.

Мах, махан бүтээгдэхүүний нийт 29 нэр төрлийн барааг ЕАЭЗХ-ны зах зээл рүү татваргүй гаргах боломжтой болж, одоогийн байдлаар ЕАЭЗХ-ны мах, махан бүтээгдэхүүний нийт импортын 0.8 хувийг (5.8 сая ам.доллар) цаашид тогтвортой нэмэгдүүлэх суурь бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулаагүй бөгөөд мах, махан бүтээгдэхүүн экспортолдог гол нийлүүлэгч зарим улстай харьцуулахад 15-аас 50 хувийн гаалийн тариф ногдуулж буй Монгол Улсын бүтээгдэхүүн "0" хувийн татвартай болох нь зах зээл дээр шууд үнийн давуу талыг бий болгож, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. ЕАЭЗХ-тай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрт мах, махан бүтээгдэхүүн нь ЕАЭЗХ-ын хувьд эмзэг бараа гэж тооцогддог ба ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан орнууд болох Вьетнам, Серби, Иран зэрэг улсын хувьд энэ төрлийн бараанд татварын хөнгөлөлт аваагүй байна. Энэ нь Монгол Улсын хувьд ЕАЭЗХ-ны махны зах зээлд өрсөлдөхөд бусад улсад олгож буй тарифын хөнгөлөлтөөс илүү өргөн хүрээний, таатай, давуу байр суурийг бүрдүүлж байна.

Монгол Улсаас ЕАЭЗХ руу экспортлох 60 нэр төрлийн арьс, ширэн бүтээгдэхүүн, 204 нэр төрлийн ноос, ноолуурын бүтээгдэхүүн, 65 нэр төрлийн сүү, цагаан идээ, малын дайвар бүтээгдэхүүн зэрэг хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн "0" тарифтай болно. Үүнээс гадна хайлуур жонш, давс, зэс, молибден, тугалга, гянтболд зэрэг ашигт малтмалын барааг гаалийн татварыг тэглүүлнэ. Манай экспортлогч аж ахуйн нэгжүүд жилд хамгийн багадаа 16.6 сая ам.долларын гаалийн татвараас чөлөөлөгдөх боломж бүрдэнэ.

ЕАЭЗХ-аас Монгол Улсад импортлох 367 нэр төрлийн бүтээгдэхүүн нь аж үйлдвэрийн, хүнсний, эрдэс-химийн гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 222 нэр төрлийн бараанд гаалийн татварыг тэглэснээр хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж, ган төмөр хийц, трансформатор, хүнд машин механизм зэрэг манай улсад үйлдвэрлэдэггүй барааг үйлдвэрлэлийн зориулалтаар хямд өртгөөр авах боломж бүрдэнэ.

Хүнсний 94 нэр төрлийн бүтээгдэхүүнд элсэн чихэр, хуурай сүү, өндөг, жимс зэрэг хүнсний орц бүтээгдэхүүн импортын татваргүй болсноор дотоодын үйлдвэрлэлийн өртөг буурна. Хүнсний салбарын өндөг, улаан буудай зэрэг бүтээгдэхүүнд квот тогтоон, зах зээлийг хамгаалах зохицуулалт тусгагдсан.

Эрдэс, химийн бүтээгдэхүүний салбарын бордоо, ургамлын хамгаалалтын бодис, витамин, вакцин, шингэн антибиотик, азотын бордоо, автобензин, дизель түлш,

шампунь, угаалгын нунтаг зэрэг газар тариалан, мал аж ахуй, эрүүл мэндийн салбарын зайлшгүй хэрэгцээтэй 51 нэр төрлийн бараанд ногдох гаалийн татварыг тэглэсэн.

Хэлэлцээрийн 19 дүгээр зүйлээр дотоодын зах зээлийг хамгаалах тусгай заалт тусгагдсан. Өөрөөр хэлбэл, тодорхой барааны импорт огцом өсөж, дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулах бодит эрсдэл бий болсон тохиолдолд Монгол Улс тул тариф нэмэгдүүлэх, квот тогтоох, тарифын хөнгөлөлтийг түр түдгэлзүүлэх, тарифын квот тогтоох зэрэг хамгаалалтын арга хэмжээг авах байдлаар дотоодын зах зээлийг хамгаалах боломжтой.

Гаалийн тарифын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх нөхцөл:

Талууд Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 6 оронгийн түвшинд ижил тооны барааг хэлэлцээрт хамруулж, гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлэхээр тохиролцсон бөгөөд тус бүр 367 барааны жагсаалт хэлэлцээрийн хавсралтаар туссан.

Тайлбар: БТКУС-ын 6 орон нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн бүх орнуудад ижил түвшинд мөрдөнө.

Хөнгөлөлт, чөлөөлөлтийг дараах 4 төрлөөр эдлүүлнэ. Үүнд:

- Гаалийн тарифыг шууд тэглэх;
- Гаалийн тарифыг 25, эсхүл 50 хувиар бууруулах;
- Квот тогтоож, заасан хэмжээнд тарифыг тэглэх;
- Квот тогтоож, заасан хэмжээнд тарифыг бууруулах.

Монгол Улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад экспортлох нийт 621 үндэсний бараанаас 611 барааны гаалийн тарифыг тэглэх бөгөөд цагаан архи, шар айргийн тарифыг 25 хувиар, бусад бяслаг барааны тарифыг 50 хувиар бууруулна. Өөрөөр хэлбэл, манай улсын экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий бараанууд татваргүй экспорт хийх боломжтой. Монгол Улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнууд руу экспортлоход одоогийн байдлаар ногдуулж буй татварын дараах хувь хэмжээ бүгд тэглэгдэнэ. Үүнд: үхрийн махны 50 хувь, адууны махны 15 хувь, махан бүтээгдэхүүний 15-аас 20 хувь, ноос ноолуурын 5-аас 10 хувь нэхмэл, оёмол эдлэлийн 18 хувь.

Тус хэлэлцээрийн хүрэх үр дүн, ач холбогдол нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдтэй нийцэх төдийгүй, төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд боловсруулах үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдтэй цаг хугацааны хувьд нийцтэй болно.

2023 оны ОХУ руу экспортын гүйцэтгэлээр тооцож үзвэл Монгол Улсын аж ахуйн нэгжүүд 1 жилд багадаа 16.6 сая ам.доллартай тэнцэх гаалийн тарифыг тэглүүлнэ.

Манай улсын стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох улаанбуудай болон өндөгний хувьд дотоодын үйлдвэрлэл, хэрэглээний хэмжээг харгалзан дотоодын

үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор квот тогтоож, тарифыг тэглэхгүйгээр бууруулах байдлаар тохирсон.

Сүүлийн 3 жилийн өндөгний дотоодын нийт хэрэглээ 448.6 сая ширхэг бөгөөд үүнээс 165 сая ширхэг буюу 36.8 хувийг импортоор нийлүүлсэн. Дотоодын өндөг үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор нийт зах зээлийн 20 хувийг импортын орон зайд хэвээр үлдээж, 90 сая ширхэг хүртэлх импортын өндөгт татварыг 50 хувь бууруулж, 7.5 хувийн татвартай байх, 90 саяас дээш импортолсон тохиолдолд татварыг хэвээр үлдээх буюу 15 хувийн татвартай байхаар тохиролцсон.

Жил бүр ургац хураалтын нөхцөл байдлаас хамааран 30.0-50.0 мянган тонн улаанбуудайг импортлох шаардлага үүсдэг. Энэ хүрээнд айлын талаас хатуу болон зөөлөн улаанбуудайд нийтдээ 180.0 мянган тонны квот санал болгосныг 50.0 мянган тонн болгон бууруулж, айлын талыг буулт хийлгэн талууд тохиролцоонд хүрсэн.

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын 2024 оны тарифын мэдээллээр ЕАЭЗХ-ны нэн тааламжтай тарифын дундаж 6.6 хувь (хөдөө аж ахуйн бараанд 9.7 хувь) байхад Монгол Улсын нэн тааламжтай тарифын дундаж 5.2 хувь (хөдөө аж ахуйн бараанд 6.3 хувь) байгаа нь Монгол Улсын гаалийн тарифын дундаж ЕАЭЗХ-той харьцуулахад харьцангуй бага байна.

Ийнхүү Монгол Улсаас экспортлох бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэснээр тухайн барааг үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадвар нэмэгдэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно.

Хэлэлцээрийн хүлээгдэж буй үр дүн:

Олон улсад чөлөөт худалдааны хэлэлцээр хийхэд түгээмэл ашигладаг “Ерөнхий тэнцвэрийн загвар” (GТAP)-ын тооцооллын дагуу хэлэлцээр хэрэгжсэнээр манай улсын ДНБ 0.02 хувь, хөрөнгө оруулалт 2.57 хувь, ЕАЭЗХ руу хийх экспорт 24.1 хувь өсөх боломжтой байна.

Монгол Улсын хувьд ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад нийт 367 бараанд гаалийн тарифын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлснээр аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадварыг нэмэгдүүлж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно.

Нийт экспортын хэмжээ 24.1 хувиар нэмэгдэнэ. Тухайлбал,

- Мах, махан бүтээгдэхүүний бүлэгт (үхрийн мах, хонь, ямааны мах, адууны мах, малын дайвар бүтээгдхүүн, утсан, нөөшилсөн мах зэрэг) хамаарах 15-аас 50 хувийн гаалийн татварыг тэглэснээр экспорт 140 хувь хүртэл өсөхөөр;

- Арьс, ширэн бүтээгдэхүүн (арьсан гарт цүнх, бээлий, савхин хувцас, нэхий, хүйтний хувцас, бүх төрлийн арьс, шир, желатин)-ий 5-аас 15 хувийн татварыг тэглэснээр экспорт 152 хувь хүртэл нэмэгдэхээр;
- Малын тэжээл, ясны шөл, биологийн идэвхт бодис, малын гаралтай бордоо, саван зэрэг бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд 5–12.5 хувийн татварыг тэглэснээр 140 хувь хүртэл өсөлт үзүүлэхээр;
- Ноос, ноолуурын хувцас, нэхмэл эдлэл, хөнжил, дэвсгэр зэрэг ноолуурын эцсийн бүтээгдэхүүнд 10-аас 18 хувийн гаалийн татварыг тэглэснээр экспортын хэмжээ 134 хувь хүртэл нэмэгдэхээр;
- Мөн гоймон, чихэр шоколад, төмс, хүнсний ногоо, чацаргана, жимсний шүүс, чанамал зэрэг хүнсний боловсруулсан бүтээгдэхүүний 8-аас 15 хувийн гаалийн татвар тэглэснээр дунджаар 51 хувийн өсөлт үзүүлэхээр;
- Архины болон шар айрагны тарифыг 25 хувиар бууруулснаар экспорт 17 хувиар өсөхөөр тус тус тооцооллын үр дүн гарсан байна.

Мөн Монгол Улсын уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэн эдийн засаг төрөлжиж, аливаа нэг улсаас хамаарах худалдааны хамаарал байдал багасаж, эдийн засаг төрөлжинө. Энэ нь эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

Монгол Улсаас ЕАЭЗХ-д экспортлох бараанд үндэсний нөхцөл олгож байгаа буюу тухайн улсын дотоодод үйлчлэх татвар, хураамжтай ижил хэмжээний татвар ногдуулах, дотоодын бараатай ижил дүрэм, журам, шаардлага тавигдах боломж бүрдсэн.

Худалдаанд шаардлагагүй саад тотгор үүсгэсэн тохиолдолд Талууд Хамтарсан хорооны түвшинд техникийн зөвлөлдөх уулзалт хийн асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдсэн. Мөн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортлох үеийн эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хялбаршуулах, тохирлын гэрчилгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээг эхлүүлэх боломж бүрдэнэ.

Гаалийн үйл ажиллагааг хялбаршуулж, хөнгөвчилсөн. Тухайлбал, гаалийн мэдээллийг цахимаар солилцох боломж бүрдэж, өндөр эрсдэлтэй бараанд хяналт, шалгалтыг төвлөрүүлж, бага эрсдэлтэй бараанд гаалийн ажиллагааг хялбарчлахаар тусгагдсан. Гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагаас хэтрэхгүй хугацаанд барааг олгохоор заасан. Тал тус бүр итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид зориулсан худалдааг хөнгөвчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цаашид эдгээр аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар холбогдох зохицуулалтыг тусгасан.

Гарал үүслийн гэрчилгээг цахимаар солилцох боломж бүрдэж, заавал эх хувийг шаардахгүй байхаар тусгагдсан. Гадаад худалдаа эрхлэгч бараагаа экспортлох үед бүрдүүлэх гарал үүслийн гэрчилгээг МҮХАҮТ-аас авах шаардлагагүй бөгөөд 5000 еврогоос хэтрэхгүй бараанд гарал үүслийн мэдүүлгийг өөрөө гаргаж болохоор тусгасан.

Ийнхүү гарал үүслийн мэдүүлгийг өөрсдөө гаргах нь цаг хугацаа, зардал хэмнэсэн, жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжсэн зохицуулалт болно.

ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай материалыг ашиглан Монгол Улсад үйлдвэрлэсэн барааг Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд тооцох боломжтой. Барааг гагцхүү тээвэрлэхэд зориулж савласан савлагаа, баглаа боодлын материал, хайрцаг савыг тухайн барааны гарал үүслийг тогтооход тооцохгүй, тухайн бараанд 50 хувиас ихгүй хувийн зохих гарал үүслийг тодорхойлсон нь барааг үйлдвэрлэхэд зарим нэг гарал үүсэлгүй материалыг ашиглах боломжийг олгосон нь үйлдвэрлэгчдэд гарал үүслийн хувьд илүү таатай нөхцөл олгоно. Дотоодын үйлдвэрлэл өссөнөөр ажлын байр нэмэгдүүлнэ. Хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

---o0o---